

МОНГОЛ ДАХЬ ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НОГООН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

Жан Сю Ө*, Б.Баярсайхан*

Технологийн хөгжлийн эрин үед дэлхийн байгаль экологийн тэнцвэрт байдал өөрчлөгдөн улс орны хөгжил, дэвшилд сөрөг нөлөөлөх төдийгүй хүний эрүүл мэндэд аюул занал учруулах боллоо. Дэлхий нийтээрээ байгаль орчинд халгүй, ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиг хандлагад нэгдэж байна.

Монгол улс бол Азийн төв хэсэгт орших далайд гарцгүй, экологийн орчин харьцангуй эмзэг улс орон юм. Сүүлийн жилүүдэд дэлхийн цаг уурын дулаарал, газар нутгийн цөлжилт гэх мэт байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр болон малын бэлчээрийн даацыг хэтрүүлэх, эмх замбараагүйгээр олборлолт хийх, усны нөөц болон зэрлэг амьтан ургамлын нөөцийг хяналтгүйгээр ашиглах гэх мэт хүний хүчин зүйлийн нөлөөгөөр Монгол орны экологийн орчинд тодорхой хэмжээний хохирол учирч байна.

1990-ээд оноос эхлэн Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа тасралтгүй өргөжиж ирлээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд хоёр орны эдийн засаг өндөр хурдтай хөгжиж байгаатай холбоотойгоор Монгол-Хятадын хамтын ажиллагаа стратегийн түншлэлийн харилцааны шинэ үе шат руу орж, хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны хөгжил шинэ түвшинд гарч байна.

Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засагт голлох байр суурийг эзэлдэг. Монгол, Хятадын уул уурхайн салбар дахь хамтын ажиллагаа бол хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны голлох салбар юм. Хятад улс нь Монголын гадаад худалдааны хамгийн том түнш орон төдийгүй Монгол улсын хамгийн том хөрөнгө оруулагч орны байр сууриа олон жил тасралтгүй хадгалсаар ирсэн. Хятадын хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхайн салбарт төвлөрч, монголын уул уурхайн бүтээгдэхүүний дийлэнх нь хятадын зах зээл рүү экспортлогдож байна.

Гэхдээ Хятадын Монгол дахь хөрөнгө оруулалтыг Монгол улсын засгийн газрын ногоон эдийн засаг, ногоон хөгжлийг хангах зорилготой уялдуулж, байгаль орчинд ээлтэй технологи Монголд нутагшуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон эдийн засагт чиглэсэн ажлын байр бий болгох, ногоон хөгжлийн чиглэлээр ур чадвартай хүний нөөц бэлтгэх зэрэг чиглэлээр Хятад улстай хамтран ажиллах шаардлага Монгол улсын хувьд байсаар байна.

* Жилин их сургуулийн Бизнесийн сургуулийн Доктор, Профессор

* Жилин их сургуулийн Бизнесийн сургуулийн докторант

Нэг. Монгол, Хятадын эдийн засаг, хамтын ажиллагааны өнөөгийн байдал

2012 оны байдлаар Монгол Хятадын худалдааны эргэлт 5921,2 сая ам.доллар болсон нь Монголын гадаад худалдааны эргэлтийн 53,2 хувийг эзэлж байна (Хүснэгт 1-с үзнэ үү).¹ Түүний дотор Монголоос Хятад улс руу гаргаж буй экспорт 4059,7 сая долларт хүрч Монголын нийт экспортын өртгийн 92,5 хувьтай тэнцэж (Хүснэгт 2-с үзнэ үү)², Монгол улсын БНХАУ-аас оруулж буй импорт 1861,6 сая долларт хүрч Монголын импортын нийт өртгийн 27,4 хувийг эзэлж байсан байна (Хүснэгт 3-с үзнэ үү). Хятад улс нь монголын гадаад худалдааны хамгийн том түнш орон юм.³

Хүснэгт 1

Гадаад худалдааны нийт эргэлт, улсаар, (сая.доллар)

Улс	2009	2010	2011	2012
Нийт	4023.1	6108.6	11415.9	11123
Үүнээс:				
БНХАУ	1932.5	3437.2	6463.7	5921.2
ОХУ	841	1129.4	1721	1927
АНУ	117.6	164.9	541.4	539.5
Канад	155	163.9	219.1	214.5
Япон	101.6	199.2	501.2	507.2
Бусад	875.4	1014	1969.5	2013.6

Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

Хүснэгт 2

Монгол Улсын экспорт,улсаар (сая.доллар)

	2009	2010	2011	2012
Нийт	1885.4	2908.5	4817.5	4384.7
үүнээс:				
БНХАУ	1393.9	2466.3	4439.9	4059.7
ОХУ	68.2	82.7	96.3	79.6
Канад	147.5	141.6	90.8	117.3
Их Британи	126.9	67.4	20	11.9
ХБНГУ	15.6	22.1	14.9	16
Бусад	133.3	128.4	155.6	100.2

Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

1. МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он
2. МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он
3. МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

Монгол Улсын импорт,улсаар (сая.доллар)

	2009	2010	2011	2012
Нийт	2137.7	3200.1	6598.4	6783.3
Үүнээс:				
БНХАУ	538.6	971	2023.9	1861.6
ОХУ	772.8	1064.7	1624.7	1847.4
БНСУ	155.1	181.8	356.7	467.8
АНУ	103.7	158.9	536	535.9
Япон	97	196.5	490.2	501.6
Бусад	470.5	627.2	1566.9	1569

Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

Байгалийн нөөц баялгаар баялаг Монгол улс нь Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны чухал түнш болж байна. Монгол улсын Хятад руу экспортолж буй гол бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, жоншны баяжмал, боловсруулаагүй газрын тос (Хүснэгт 4-с үзнэ үү), Хятадаас оруулж буй импортын гол нэрийн бүтээгдэхүүнд машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэлгээрийн сэлбэг болон газрын тосны бүтээгдэхүүн, өргөн хэрэглээ, хүнсний бараа багтаж байна (Хүснэгт 5-с үзнэ үү).⁴

Хүснэгт 4

Монгол Улсын экспортын гол нэрийн бараа

	Нэгж	2009	2010	2011	2012
Нүүрс	Мян.тн	7113.2	16726.2	21296	20915
Боловсруулаагүй газрын тос	Мян.баррель	1938.5	2070.8	2553.7	3568
Малын дайвар бүтээгдэхүүн	Тн	568	2048.6	414.6	821.2
Зэсийн баяжмал	Мян.тн	587	568.7	575.9	574.3
Жоншны баяжмал	Мян.тн	314	405.6	407.1	428.9

Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

4. <http://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2012/201212.pdf>

Импортын бүтэц, барааны бүлгээр

Барааны бүлэг	2009	2010	2011	2012
Нийт:	100	100	100	100
Эрдэс бүтээгдэхүүн	26.7	23.6	19.3	23.5
Машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд анги	19.8	21.3	27	24.5
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн	7.7	6.3	9	8.7
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	8.3	7.5	5	5.9

Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл, 2012 он

Мөн Хятад нь Монгол улсын хамгийн том хөрөнгө оруулагч орны байр сууриа олон жил тасралтгүй хадгалсаар ирсэн. Одоогоор Монгол, Хятадын аж ахуйн нэгжүүд геологи уул уурхайн хайгуул ашиглалт, хоол хүнс, худалдаа, барилга, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах гэх мэт салбарт өргөнөөр хамтран ажиллаж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаний тоо

Улс	Хувь	Нийт	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Нийт ГХОК-ийн тоо	100	12416	3691	971	1505	1609	1551	613	769	933	774
БНХАУ	49	6083	1534	532	827	876	859	299	376	434	346
БНСУ	18	2196	632	203	274	332	302	113	117	122	101
ОХУ	7	824	433	54	105	72	51	37	17	34	21
Япон	4	525	190	29	56	60	58	35	23	35	39
АНУ	2	292	98	19	28	27	44	11	14	36	15

Эх үүсвэр: ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын бүртгэлийн газар

2013 оны эхний 6 сарын байдлаар Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо 6189 болж, гадаадын нийт хөрөнгө оруулалттай компаний 50 орчим хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ ч улам нэмэгдэж, түүн дотор геологи, уул уурхайн хайгуул, ашиглалт, газрын тосны салбар хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлж 2563.3 сая ам.доллар болсон нь хятадын нийт хөрөнгө оруулалтын 68,5 хувийг эзэлж байна.⁵

Хүснэгт 7.

Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалт, салбараар (сая. доллар)

Салбар	%	Нийт	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012*
Геологи уул уурхай	69	2563	185	165	103	247	429	558	128	683	59
Худалдаа, нийтийн хоол	20	758	120	29	52	84	63	51	43	181	131

Эх үүсвэр: ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын бүртгэлийн газар

Гэхдээ хоёр талын хамтын ажиллагаа гүнзгийрч байгаатай холбоотойгоор анзааралгүй орхигдуулж болохгүй, хоёр орны ард түмний харилцан итгэлцэл, нөхөрлөлийн харилцаанд нөлөөлж болохуйц Хятадын зарим нэг компанитай холбогдох асуудлууд гарч ирж байна. Жишээ нь: Дорнод аймгийн Матад сумын Буян-Өндөр багийн нутагт газрын тос олборлох үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин Тамсаг” компани болон Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах Нарантолгойн алтны үндсэн томоохон ордод үйл ажиллагаа явуулж буй Тэн Хун ХХК –ийг нэрлэж болно.

Монголын судлаачдын мэдээллээс үзэхэд “Петрочайна Дачин Тамсаг” компани нь дараах асуудлуудыг үүсгэсэн байна.⁶ Үүнд:

- 2010 оноос хойш иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл шүүхээр заргалдаж, Петрочайна Дачин Тамсаг компанийн байгаль орчныг доройтуулсаны нөхөн төлбөр 1.3 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн нь гурван шатны шүүхээр давж заалдаад тус компанийн буруутай болохыг тогтоож, төлбөрийг орон нутгийн төсөвт оруулах шийд гарсан. Гэсэн ч өнөөг хүртэл энэ төлбөрийг төлөөгүй байна.

5. ЭЗХЯ, Гадаадын хөрөнгө оруулалт зохицуулалт, бүртгэлийн газар

6. Өнөөдөр сонин. 2013.03.13

• 2011 онд Бичигтийн боомт хүртэл хар зам тавина гэж засгийн газартай хийсэн гэрээнд үзэглэсэн ч энэ замаа тавиагүй бөгөөд өнөөг хүртэл газрын тос тээвэрлэх явцдаа 31 салаа зам үүсгэжээ.⁷ Петрочайна Дачин Тамсаг компаний 60-100 тоннын тос газрын тос багтдаг том оврын 80-100 машинууд тал нутагт дураараа зам гаргаж, малын бэлчээрт ноцтой хохирол учруулдаг талаар иргэний нийгмийн байгууллагуудын судалгаанд тусгагджээ.⁸

Мөн Төв аймгийн Жаргалант суманд байрлах Нарантолгойн алтны үндсэн ордод үйл ажиллагаа эрхэлж буй “Тэн Хун” компанийн хариуцлагагүй үйл ажиллагаа монгол иргэдийн бухимдлыг төрүүлж байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2013 оны 6 сард хийсэн шалгалтын мэдээгээр “Тэн Хун” ХХК нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйд ойн зурвас байгуулаагүй, хашаа хамгаалалт хийгээгүй, ашигласан бохир ус, алт олборлосон угаадас зэргийг хөрсөнд шингээж байгаа зэрэг томоохон зөрчлийг нэрлэж болно.

Хоёр. Хятад Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд оршин буй асуудал, авбал зохих арга хэмжээ

Хэдийгээр хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээ түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрээд байгаа хэдий ч энэхүү үзүүлэлтүүдийн ард хэн хэн нь анхаарвал зохих асуудал нилээд байна. Үүнд:

1. Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын талаарх бодлого тодорхой бус, холбогдох хууль батлагдахгүй удсанаас гадаадын хөрөнгө оруулалт нэг салбарт хэт төвлөрч байна. Үүнийг Хятад улсаас Монгол улсад оруулж буй хөрөнгө оруулалтын бүтцээс харж болно.

2. Нэг талаас гадаадын хөрөнгө оруулалттай компани ашгийг чухалчилж, улайрч олборлох, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг тухайд нь гүйцэтгэхгүй байх тал түгээмэл ажиглагддаг.⁹ Мөн нөхөн сэргээлтийн зардлыг бага тусгадаг талтай. Энэ нь нөгөө талаас монгол улсын төр захиргааны байгууллагын зүгээс уурхайг ашиглаж буй явцад хийгдэж буй нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах бус, харин олборлож дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагааг хянаж, үр дүнг хүлээж авах алдаатай бодлого баримталж байгаагийн илрэл юм.

3. Гүний усыг хяналтгүй, хайр гамгүй ашиглаж байна.

4. Үйл ажиллагааг технологийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай байна. Зарим уул уурхайн компаниудын хувьд хаягдлын сангаас шүүрэлт өгөх, хаягдлыг шууд байгальд шингээх тал ажиглагддаг.

5. Монголд уул уурхайн олборлолтонд хөрөнгө оруулалт хийж буй

7. <http://mongolnews.mn/i/40275>

8. <http://matad.wordpress.com/2013/03/14>

9. МХЕГ-ын байгууллагын мэдээлэл, 2013

аж ахуйн нэгжүүдийн дунд Хятадын хувийн аж ахуйн нэгжүүд томоохон байр суурийг эзэлдэг. Тэдгээрийн зарим нь Хятадад аль хэдийн хэрэглэхээ больсон хоцрогдсон технологи, байгаль орчныг ноцтой бохирдуулж буйн улмаас хятадад хаагдсан, зогсоосон төслийг монголд оруулж ирэх, мөн байгаль орчинг нөхөн сэргээх арга хэмжээг авахгүй байгаагаас монголын байгаль орчинд маш ноцтой хохирол учруулж байна.¹⁰ Жишээ нь Налайх дахь тоосгоны үйлдвэрүүдийг энд дурдаж болно. Үүнийг зохицуулах талаар тусгайлсан эрхзүйн баримт бичиг боловсруулах шаардлага байсаар байна.

6. Монголын засгийн газраас холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

7. Монгол улсын дэд бүтэц харьцангуй хоцрогдсон учир авто зам, төмөр зам гэх мэт байгууламжуудыг цаг алдалгүй өргөн цар хүрээгээр засварлах, барихыг чухалчлах нь зүйтэй.

8. Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг хөрш орнуудын газар нутгаар дамжин өнгөрөх талаар гурван талын тохиролцоонд хүрэх шаардлагатай

Хятадын аж ахуйн нэгжүүдийн хувьд дараах зүйлсэд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Монгол улсын үйлдвэрлэлийн талаарх бодлогын дагуу судлаж хөрөнгө оруулалтын бүтцээ зохицуулж, хамтын ажиллагааг олон салбарт нэмэгдүүлэх;

2. Одоо хэлэлцэж буй гадаадын хөрөнгө оруулалтын шинэ хуулиар байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх, шинээр ажлын байр бий болгох, шинэ техник технологи нэвтрүүлж буй эсэх шалгуурыг хангасан хөрөнгө оруулагчдад “Тогтворжуулах гэрчилгээ олгоно” гэж тусгасан. Энэ шалгуурыг хангаж ажиллах тал дээр анхаарах;

3. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд олон улсын хууль дүрмийг мөрдөх ёстой. Уул уурхайн салбар дахь аж ахуйн нэгжүүд байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах;

4. Эрт дээр үеэс Монголын ард түмэн байгалийг хайрлан хамгаалах, ариг гамтай ашиглах түүхэн уламжлалтай улс билээ. Энэ уламжлалыг хүндэтгэн ажиллаж, хоёр орны иргэдийн харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;

5. Дэлхийн цаг уурын дулаарал, газар нутгийн цөлжилттэй тэмцэх гэх мэт холбогдох чиглэлээр Монгол улстай хамтран ажиллах шаардлага байна;

10. Түмэнцэцэг. Хятад Монголын эдийн засаг, худалдааны өнөөгийн байдал, оршин байгаа асуудал болон авбал зохих арга хэмжээ. 2013 он

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг эзэлж буй Хятадын хөрөнгө оруулалтын бүтцийг өөрчилж, олон салбарт, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт хамтын ажиллагааг нэмэгдүүлэх бүрэн боломж бий.

Монгол улс 1993 онд НҮБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенци”, 1999 онд “Киотогийн протокол”-д тус тус нэгдэж, 2005 онд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, 2007 онд “Сэргээгдэх эрчим хүчний хууль”, 2010 онд “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх үндсэн зорилт тавин ажиллаж байна.

1. 2005 онд батлагдсан сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрт: Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг шат дараатай хэрэгжүүлэн 2010 оны түвшинд улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 3-5 хувь, 2020 оны түвшинд 20-25 хувийг сэргээгдэх эрчим хүчийг ашиглан үйлдвэрлэх;

2. 2007 онд батлагдсан сэргээгдэх эрчим хүчний хуульд: 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр ашиглах;

3. Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөрт: сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг суурилагдсан чадлын 20 хувьд хүргэх, хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувиар бууруулах гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монголтой хил залгаа орших хөрш орны хувьд хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ Монгол улсын экологийн орчинг хамгаалах, ялангуяа уул уурхайн баялгийг олборлохдоо хууль дүрмийг хүндэтгэн хүрээлэн буй орчинг хамгаалах тал дээр идэвхитэй хамтарч ажиллах ёстой. Монгол улс Хятад улсын туршлага, сургамжаас сайн суралцах, байгаль орчинг хамгаалах идэвхитэй, үр ашигтай хууль, бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Уул уурхайн салбарт ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нь манай хоёр орны хоёулангийнх нь эрх ашигт нийцэж байгаа учир энд хамтын хүчин чармайлт чухал юм.

Ашигласан номзүй

1. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. “МУ-ын статистиктийн эмхэтгэл”, Улаанбаатар, 2012
2. “Ногоон хөгжлийн талаар баримтлах Монгол улсын үндэсний стратеги” бодлогын баримт бичгийн төсөл
3. Монгол Улсын Засгийн Газар, Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл”, УБ, 2012
4. НҮБХХ, “Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго”, УБ, 2012
5. Түмэнцэцэг. “Хятад Монголын эдийн засаг, худалдааны өнөөгийн байдал, оршин байгаа асуудал болон авбал зохих арга хэмжээ”, 2013
6. ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын бүртгэлийн газрын мэдээлэл
7. <http://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2012/201212.pdf>
8. Өнөөдөр сонин. 2013.03.13
9. <http://mongolnews.mn/i/40275>
10. <http://matad.wordpress.com/2013/03/14>
11. МХЕГ-ын байгууллагын мэдээлэл, 2013